

2006 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

*Б.Мандхай**

- 01.06 Монгол Улсын шадар сайд Улаан БНАСАУ-аас манай улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Пак Жен До-г өөрийх нь хүсэлтээр хүлээн авч уулзав. Улс орныхоо байдал шинэ зорилтын талаар элчин сайд мэдээлээд хоёр орны харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, ялангуяа хөдөө аж ахуй газар тариаланд түлхүү анхаарч, бас барилга эрүүл мэнд шинжлэх ухааны салбарт ч хамтран ажиллах болно гээд байгуулсан гэрээ, тавьсан зорилтоо хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ хүслээ. Ч.Улаан хоёр орны найрамдалт харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө анхаарч, эдийн засаг хөдөө аж ахуй, соёл шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах өргөн боломж байгааг бодит ажил хэрэг болгохын чухлыг онцлов.
- 01.23 УИХ-ын дэд дарга Д.Лүндээжанцан Япон улсын Онц бөгөөд Бүрэн эрх элчин сайд ноён Я.Ишихаши-г хүлээн авч уулзаж ярилцав.
- 02.06 УИХ-ын дарга Ц.Нямдорж тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын явцад УИХ-ын дарга БНСУ-ын ерөнхийлөгч Но Мү Хёнд бараалхан үндэсний Ассамблейн дарга Ким Вон Ги-тэй албан ёсны уулзалт хийв мөн. Айлчлалын үеэр хоёр орны парламент дахь найрамдлын бүлгийн дарга нарын уулзалтад оролцов.
- 02.08 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт БНТУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Өмүр Шөлэчдил итгэмжлэх жуух бичгээ барив.
- 02.18 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Чан Нгуэн Чыгийг эх орондоо бүрмөсөн буцах болсонтой нь холбогдуулан хүлээн авч уулзав. Ази, Номхон Далайн бүс нутагт Вьетнамын харилцаа, хамтын ажиллагааг бололцоотой бүх л салбарт гүнзгийрүүлэн хөгжүүлэхийн төлөө цаашид ч идэвхи зүтгэл гарган ажиллахаа илэрхийлэв.

* Б.Мандхай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

- 03.14 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт БНСУ-аас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Пак Цин Хо итгэмжлэх жуух бичгээ өргөн барив.
- 03.18 Монгол Улсад АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга асан Жеймс Бейкер айлчлав. Хүндэт зочин айлчлалын үеэрээ ерөнхийлөгч Н.Энхбаяр, ерөнхий сайд М.Энхболд нартай уулзаж ярилцсан бөгөөд ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэн, Стратеги Судалгааны хүрээлэнд тус тус зочлов.
- 03.21 Монгол Улсын ерөнхий сайд М.Энхболд Япон улсын Засгийн газрын урилгаар тус улсад 2006 оны 3 сарын 26-30 ны өдрүүдэд айлчлав.
- 03.29 Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр 3 сарын 27-30 нд Унгар улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалаар хоёр орны хууль зүй, дотоод хэргийн яамдын хооронд хамтран ажиллах протоколд гарын үсэг зурав.
- 03.30 Монгол Улсын сангийн сайд Н.Баяртсайхан Япон улсад албан ёсны айлчлал хийж, Токио хотноо Япон улсын засгийн газар, Монгол Улсын засгийн газарын хооронд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөлд гарын үсэг зурав.
- 04.10 БСШУ-ны сайд Ө.Энхтүвшин, БНЭУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Гаури Шанкара нар Монгол Улсын засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг улсын засгийн газрын хооронд МУИС-д Буддын болон Санскрит судлалын төв байгуулах тухай санамж бичигт гарын үсэг зурав.
- 04.17 Гадаад хэргийн яаманд Япон улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ё.Ичихаши: Япон улсын засгийн газраас “Хүнсний хангамжийг сайжруулах” КР-1 төслийн хүрээнд 200 сая иений үнийн дүн бүхий хүнсний тусламжийг үзүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурав.
- 04.29 Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан тэргүүтэй төлөөлөгчид БНТУ-д албан ёсны айлчлал хийж, Туркийн Үйлдвэр худалдааны сайд Али Жошкун, Төрийн сайд, Соёл, аялал жуулчлалын сайд Атилла Коч, Гадаад худалдааны хорооны дарга Т.Каяалар нартай уулзаж Монгол-Туркийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, зарим төсөл хэрэгжүүлэх

- талаар ярилцав. Мөн Алтанбулаг чөлөөт бүсийн захиргаа, БНТУ-ын гадаад хорооны чөлөөт бүсийн ерөнхий захиргааны хооронд хамтран ажиллах протоколд гарын үсэг зурав.
- 05.06 МУ-ын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Н.Энхбаярт БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд М.М.Ражу бараалхан хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэх талаар ярилцлаа.
- 05.20 Малайз улсын Гадаад хэргийн сайд Дато Сери Саед Хамид Албар Монгол Улсын Гадаад хэргийн сайд Н.Энхболдтой албан ёсны хэлэлцээ хийж хоёр талын хамтын ажиллагаа болон бүс нутгийн хийгээд олон улсын харилцан сонирхсон асуудлаар харилцан санал солилцов.
- 06.15 Гадаад хэргийн сайд Н.Энхболд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын дээд хэмжээний уулзалтад оролцов. Тус уулзалтын үеэр ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровтой уулзалт хийж, хоёр улсын гадаад хэргийн яамдын хооронд 2006-2007 онд хамтран ажиллах чиглэл, харилцан хийх айлчлал, уулзалт, санал солилцох сэдэв, чиглэлийг тодорхойлон төлөвлөж гарын үсэг зурлаа.
- 06.24 Москва хотын дарга Ю.М.Лужков манай улсад албан ёсны айлчлал хийж, хоёр хотын дарга Улаанбаатар, Москва хотын хооронд 2006-2008 онд хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурав. Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар Москва хотын дарга Ю.М.Лужковыг “Алтан гадас” одонгоор шагнав.
- 08.19 Тайландын Вант улсын Гадаад хэргийн сайд Кантати Суламонгкон, гэргий Сопорван Сульмонгконы хамт Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.
- 09.23 Монгол Улсын ерөнхий сайд М.Энхболд НҮБ-ийн ерөнхий Ассамблейн чуулганд оролцож, НҮБ-ийн индэр дээрээс 2005 оны дээд хэмжээний уулзалтаар дэлхийн хэмжээний 150 гаруй улсын төр засгийн тэргүүн энх тайван, хөгжил, хүний эрхийг хамгаалахын төлөө үйл ажиллагааны тодорхой хөтөлбөр батлагдсанаас хойш түүнийг ажил хэрэг болгоход олон улсын хамтын нийгэмлэг багагүй ахиц гаргалаа хэмээн цохон тэмдэглэв.

- 09.23 Байгалийн эдийн засаг (БЭЗ)-ийн дөрөвдүгээр чуулга уулзалтад оролцож байгаа УИХ-ын дарга Нямдорж тэргүүтэй төлөөлөгчдийг ОХУ-ын холбооны хурлын, холбооны зөвлөлийн дарга С.М.Миронов хүлээн авч уулзав.
- 10.05 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхэт элчин сайдаар томилогдсон О.Эрдэнэчимэгт итгэмжлэх жуух бичгийг гардуулж өгөв.
- 10.09 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын ерөнхий нарийн бичгийн дарга ноён Марк Перрин Бришамбо бараалхлаа.
- 10.12 Монгол Улсын Засгийн газар, Бельгийн Вант улсын Засгийн газар хооронд харилцан тохиролцсон “Зүүн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх” төслийн зээлийн хэлэлцээрийн тухай хэлэлцэж, Бельгийн тал 4.5 сая еврогийн хөнгөлөлттэй зээл олгохоор болжээ.
- 10.13 Монгол Улсад Канад улсын парламентийн нийтийн танхимийн дарга Спикер Питер Андрю Стюарт Миллихен тэргүүтэй төлөөлөгчид УИХ-ын дарга Ц.Нямдоржийн урилгаар айлчилж, Монгол Улсын ерөнхий сайд М.Энхболдтой уулзав. Ерөнхий сайд М.Энхболд Монгол, Канад улсын хувьд төр засгаас хэрэгжүүлж байгаа эдийн засгийн чиглэлийн бодлого, үйл ажиллагаанд адил зүйл бийг онцолж, уул уурхайн салбарын хөгжлийг эрчимжүүлэх тал дээр хоёр орны зүгээс гол анхаарлаа хандуулж байдгийг онцлон тэмдэглэлээ.
- 10.13 Ерөнхийлөгч Н.Энхбаяр манай оронд албан ёсны айлчлал хийсэн БНБУ-ын Батлан хамгаалахын сайд В.В.Близнаков тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр ерөнхийлөгч Монгол, Болгар хоёр улс уламжлалт найрсаг харилцаатай орнууд болохыг тэмдэглээд энэхүү айлчлал нь хоёр орны харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болно гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.
- 10.16 Ерөнхий сайд М.Энхболд АНУ-ын Гадаад бодлогын консулын ерөнхийлөгч Херман Пирчнер тэргүүтэй төлөөлөгчдийг төрийн ордонд хүлээн авч уулзаж, АНУ-

- ын гадаад бодлогын консулын ерөнхийлөгч Х.Пирчнертэй үндэсний эв нэгдлийн засгийн газрын бодлого, Монгол Улсын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, боломж эрх зүйн орчны талаар товч ярилцаад Америкийн томоохон аж ахуй нэгжүүд, Монгол Улсын ашигт малтмал уул уурхайн салбарт хөрөнгө оруулж хамтран ажиллах сонирхолтой байгаа цаашид уул уурхай, дэд бүтэц хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, аялал жуулчлал, банк санхүүгийн салбарт болон экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Америкийн хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах сонирхолтой байгаагаа хэлэв.
- 10.28 Бүгд Найрамдах Грек Улсын Гадаад хэргийн яамны Ази, далайн орнуудын газрын захирал Ионнис Теофанопоулос манай оронд айлчилж хоёр улсын ГХЯ хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалт хийв. Зөвлөлдөх уулзалтын үеэр Монгол, Грекийн харилцаа хамтын ажиллагааны өнөөгийн байдлын талаар болон олон улсын сонирхсон бусад асуудлаар хоёр тал санал солилцов.
- 11.06 Бүгд Найрамдах Казахстан Улсын Гадаад хэргийн сайд К.К.Токаев манай улсад албан ёсны айлчлал хийж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар санал солилцон, хоёр улсын гадаад хэргийн сайд нар албан ёсны хэлэлцээ хийлээ.
- 11.09 Монгол Улс, Польш улсад 29.9 сая шилжих рублийн өртөй байсан нь энэ өдөр шийдэгдэв. УИХ-ын гишүүн, Сангийн сайд Н.Баяртсайхан, Польш улсаас манай улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Збигнив Кулак нар өрийн асуудлыг шийдэх чухал баримт бичигт гарын үсэг зурав.
- 11.10 Гадаад хэргийн сайд Н.Энхболд Кувейт улсад албан ёсны айлчлал хийж, тус улсын ерөнхий сайд Шейх Насер Аль-Мохамед Аль-Ахмед Аль-Сабахт бараалхаж, хоёр талын харилцааны асуудлаар санал солилцов.
- 11.11 Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Р.Жигжид Японы цог жавхлант эзэн хаанд итгэмжлэх жуух бичгээ өргөн барив.

- 11.13 Японы засгийн газрын урилгаар Япон улсад айлчилж буй Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Б.Одончимэд Япон улсын Хууль зүйн сайд Ж.Нагасэ-тэй уулзаж ярилцав. Уулзалтын үеэр Монголоос дадлагажигч ирүүлэхэд тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг арилгах, Японоос өндөр насны тэтгэвэртээ гарсан мэргэжилийн хүмүүсийг өөрийн орны хэрэгцээт салбаруудад хүлээн авч зөвлөх мэргэжилтнээр ажиллуулах зэрэг асуудлыг хөндөж дэлгэрэнгүй санал солилцов.
- 11.13- 11.14 БСШУ-ны сайд Ө.Энхтүвшин Египетийн Каир хотноо “Үр дүнд түргэн хүргэх санаачлагын түншлэлийн дээд хэмжээний уулзалт”-нд оролцов. Сайд Ө.Энхтүвшин дээд хэмжээний уулзалтад өөрийн орны боловсролын талаар илтгэл тавьж хэлэлцүүлээ. Монгол Улс тус түншлэлийн гишүүн болсноор 2007-2009 онуудад боловсролын салбарт хандивлагч орнуудаас тусламж авах эрхтэй болов.
- 11.16 Монгол Улсаас Малайз улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд н.Батсуурь Малайз улсын цог жавхланта ван Туанку Саид Сиражуддин Туанку Саид Путра Жамалулайд Куала-Лампур хотноо итгэмжлэх жуух бичгээ барив.
- 11.17 Сангийн сайд Н.Баяртсайхан болон Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн зөвлөх хуульч Нафаф Ал Махамель нар Кувейтийн засгийн газрын дэргэдэх буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурав. Тусламжаар олгож буй 12 сая ам.долларыг парламентийн ордон барихад зориулна.
- 11.17 Монгол Улсын ерөнхий сайд М.Энхболд Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ё.Вармаг хүлээн авч уулзав. Үндэсний эв нэгдлийн засгийн газрын тэргүүн хоёр орны харилцааг олон салбарт өргөжүүлэн хөгжүүлэхэд шинээр томилогдсон элчин сайдыг хувь нэмрээ оруулна гэдэгт эргэлзэхгүй байгаагаа илэрхийлэв.
- 11.22 Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Грек Улсын Засгийн газрын хооронд 2006-2009 онд соёл, боловсролын салбарт хамтран ажиллах солилцооны хөтөлбөрт Монгол Улсаас БНГУ-д суугаа Онц бөгөөд

- 11.23 Бүрэн эрхт элчин сайд Б.Батхишиг, БНГУ-ын Гадаад хэргийн яамны ерөнхий нарийн бичгийн дарга Чарламбос Роканас нар Афин хотноо гарын үсэг зурав. Ерөнхий сайд М.Энхболд БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Вэн Зябаотай албан ёсны хэлэлцээр хийж Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны дарга У Бангуотай уулзав. Түүнийг Сангийн сайд Н.Баяртсайхан, Зам тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүх, Гадаад хэргийн дэд сайд С.Шолмон, Үйлдвэр худалдааны дэд сайд Я.Содбаатар болон УИХ-ын гишүүн Л.Гансүх, М.Зоригт, Д.Дэмбэрэл, нар дагалдав. Айлчлалын үеэр Монголын талаас 2 орны ерөнхий сайдын энэ удаагийн уулзалт нэн амжилттай болсон бөгөөд тодорхой олон асуудлаар хоёр тал тохиролцоонд хүрэв.
- 11.27 Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан Япон улсад ажлын айлчлал хийв. Сайд айлчлалын үеэр Японы Эдийн засаг, худалдаа аж үйлдвэрийн сайдтай уулзаж, уул уурхайн салбарынхны дугуй ширээний уулзалтад оролцов.
- 11.28 Эрүүл мэндийн сайд Л.Гүндалай БНСВУ-ын Эрүүл мэндийн сайд Чан Тки Чунг Жиен тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзав. Хоёр улсын эрүүл мэндийн яамныхан 2002 онд хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Энэ удаа уламжлалт анагаах ухаан, халдварт өвчнөөс сэргийлэх болон нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр хамтарч ажиллах талаар хэлэлцэв.
- 11.30 УИХ-ын дэд дарга Д.Лүндээжанцан АНУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд ноён Марк К.Минтоныг хүлээн авч уулзав. АНУ-ын ерөнхийлөгч болон Конгрессын төлөөлөгчдийн танхмын даргын Монгол Улсад тус тус хийсэн айлчлал нь Монгол, Америкийн харилцааг өндөр шатанд гаргасныг УИХ-ын дэд дарга онцлон тэмдэглээд Монголд парламентат ёсыг хэвшүүлэн хөгжүүлэх талаар хийх зүйл байнгын хороодын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлж буй төслийг үр дүнтэй

- үргэлжлүүлэхийн төлөө ажиллаж байгаагаа тэрээр илэрхийлэв.
- 12.01 Гадаад хэргийн сайд Н.Энхболд, Япон улсын гадаад хэргийн сайд Асотай Телефон нар уулзалт хийв.
- 12.04-12.09 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины урилгаар Москва хотноо айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путинтэй албан ёсны хэлэлцээ хийж, айлчлалын үеэр Монгол, Оросын хилийн дэглэм, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2006-2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр болон “Монголросцветмет” нэгдлийн талаар хоёр улсын хооронд байгуулах хэлэлцээр, хоёр орны аюулгүй байдлын зөвлөлийн хамтын ажиллагаа зэрэг 14 баримт бичигт гарын үсэг зуржээ. Мөн айлчлалын үеэр ерөнхийлөгч Бүгд Найрамдах Буриад Улс, Новосибирск муж болон Халимагт зочилж, орон нутгийн удирдлагуудтай уулзав.
- 12.05 УИХ-ын дэд дарга Лүндээжанцан, гишүүн Т.Очирхүү нар ОХУ-ын төрийн Думын урилгаар нэгдмэл Орос улс намын ҮШ их хуралд оролцов.
- 12.12 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд А.Одончимэд Турк Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын урилгаар тус улсад айлчлав. Айлчлалын үеэр хөдөлмөр жуулчлалын үйл ажиллагаа болон хөдөлмөрийн зах зээлтэй танилцан, Туркийн алдарт “Сабанжи” музейд дэлгэсэн “Чингис хаан ба түүний үр сад” музейг нээх ёслолын ажиллагаанд оролцов. Чингис хааны холбогдолтой ховор үзмэрийг дэлхийн улс орнуудаас цуглуулан музей байгуулсныг өмнө нь Австри, Герман улс ард түмэндээ дэлгэн сонирхуулж байсан бол БНТУ гуравдагч нь болов.
- 12.13 Монгол Улсын гадаад хэргийн сайд Н.Энхболд Катар улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үр дүнд катарын засгийн газраас Монгол улсын “Мянганы зам” төсөлд зориулж 10 сая ам.долларын буцалтгүй тусламж олгохоор болов
- 12.14 Уул уурхайн салбарт дэлхийд тэргүүлэх байр суурь эзэлдэг “Рио Тинто” компанийн захирал Брэт Клайтон тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхаж уул уурхай, эрчим хүчний

- салбарт хөрөнгө оруулалт хийн, хамтран ажиллах талаар санал солилцов. Төрийн тэргүүн гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж буйг тэмдэглээд, ашигт малтмалын олборлолт, ашиглалт нь гагцхүү Монголын нийт иргэд мөн хөрөнгө оруулагчдад харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурлан явагдах ёстойг тэмдэглэлээ.
- 12.15-12.19 Зэвсэгт Хүчний Жанжин Штабын дарга, дэслэгч генерал Ц.Тогоо тэргүүтэй төлөөлөгчид Турк Улсын зэвсэгт хүчний командлагч, генерал Өзкекийн урилгаар БНТУ-д албан ёсны айлчлал хийв. Албан ёсны айлчлал БНТУ-ын батлан хамгаалах бодлого аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад харилцаа, Монгол, Туркийн цэргийн харилцааны асуудлаар санал солилцож хэлэлцээ хийв.
- 12.18-12.21 Монгол, Вьетнамын засгийн газар хоорондын XII хуралдаан Улаанбаатар хотноо болов. XII хуралдаан дээр Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсгийн дарга ЗТАЖ-ын сайд Ч.Цэнгэл хоёр улс нь хүнс, хөдөө аж ахуй, дэд бүтэц түүний дотроос сэргээгдэх эрчим хүч, боловсрол, соёл шинжлэх ухаан, уламжлалт анагаах ухаан зэрэг салбарт хамтран ажиллах өргөн боломж байгааг онцлон тэмдэглэлээ. Уг хуралдаанд худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан техникийн Вьетнам, Монголын засгийн газар хоорондын хамтарсан комиссын Вьетнамын хэсгийн дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн дэд сайд Буи Ба Бонг тэргүүтэй тус улсын төлөөлөгчид оролцов.
- 12.21 Монгол Улсын ерөнхий сайд М.Энхболд Бүгд Найрамдах Турк Улс дахь Монголын өргөмжит консул Өмер Али Айдинерыг хүлээн авч уулзав.
- 12.23 Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралтын урилгаар БНХАУ-ын Барилгын яамны сайд Ван Гуан Тао тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчлав. Хоёр орны барилгын байгууллагуудын хамтын ажиллагааны санамж бичигт сайдууд гарын үсэг зурлаа.
- 12.25 Монгол Улсын ЗХЖШ-ын даргын урилгаар ОХУ-ын зэвсэгт хүчний жанжин штабын дарга, батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал Ю.Н.Балуевский тэргүүтэй ОХУ-ын цэргийн

төлөөлөгчид манай оронд албан ёсны айлчлал хийв. Армийн генерал Ю.Н.Балуевский ЗХЖШ-т зочилон, Монгол Улсын ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Тогоотой хэлэлцээ хийж хоёр орны цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар санал солилцож харилцааг улам сайжруулах чиглэлд тодорхой тохиролцоонд хүрэв. ОХУ-ын цэргийн төлөөлөгчид айлчлалынхаа үеэр Монгол Улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Н.Энхбаяр, УИХ, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд М.Сономпил нарт бараалхаад хоёр орны цэргийн хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, цаашдын зорилтоо тодорхойлов.

12.27

Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Б.А.Говорин бараалхав. Элчин сайд Б.А.Говорин Монгол Улсын ерөнхийлөгчийн ОХУ-д хийсэн төрийн айлчлал амжилттай болж, өргөн цар хүрээтэй асуудлыг хэлэлцэн, харилцаа хамтын ажиллагааны тодорхой тохиролцоонд хүрснийг тэмдэглээд айлчлалын үеэр яригдсан асуудлыг бодит ажил хэрэг болгоход хоёр улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрууд чухал үүрэгтэй тул харилцааг илүү идэвхжүүлэх хэрэгтэй болон худалдаа эдийн засгийн харилцааг ойрын хугацаанд нэг тэрбум ам.долларт хүргэх тохиролцоонд хүрснийг үе шаттайгаар хэрэгжүүлэх тухай дурдав.